**ТӨВ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН**
**МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР III БАРИМТ БИЧГИЙН ХҮРЭЭНД**
**ХЭРЭГЖҮҮЛЭХ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

**2024.11.19** **Зуунмод**

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт |
|---|---|---|---|
| **Нэг. Монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэх** | | | |
| 1.1 | Крилл болон монгол бичгээр албан хэрэг хөтлөх батлагдсан стандартын сургалт зохион байгуулах | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | Архив, бичиг хэргийн эрхлэгч Б.Уянга монгол бичгийн цахим бичвэрийн сургалтад хамрагдсан.<br>Албан хаагчдын үндэсний бичгээр цахимд бичих чадварыг дээшлүүлэх, албан хэргийг хос бичгээр боловсруулах, хэвлэх чадварт сургах зорилгоор “Хос бичигтэн” аян зарлаж долоо хоног бүрийн 1 өдрийн ажлын 2 цагийг монгол бичгээр бичих байти фонтын тохиргоог хийн бие даан судалж байна.<br>2024.04.01-ний өдрөөс албан хэрэг хөтлөлт/албан бичиг/-ийг хос бичгээр үйлдэн туршилтын журмаар хэрэгжүүлж байна.<br>Хэрэгжилт 100% |
| 1.2 | Монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтад албан хаагчдыг хамруулах | Монгол бичгийн бичих, унших чадварын түвшин ахисан албан хаагчдын тоо | <br>Монгол бичгийн анхан шатны сургалтад албан хаагчдыг хамруулж 8 албан хаагчийн унших, бичих чадварын түвшин сайжирсан. Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн Монгол бичгийн түвшин тогтоох сорилд хэлтсийн 18 албан хаагч, аймгийн ЗД-ын нэрэмжит үзлэгээр Монгол бичгийн түвшин тогтоох шалгалтанд 24 сумын улсын бүртгэгч, Төв аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс Хэлний бодлогын салбар зөвлөлөөс байгууллагын Монгол бичгийн түвшин тогтоох сорилд хэлтсийн 15 албан хаагч тус тус хамрагдсан.<br>Хэрэгжилт 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 1.3 | Байгууллагын нэр хаяг, өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудас, танилцуулга, мэдээллийн самбар, албан хэрэгцээний баримт бичгийн хаяг  зэргийг монгол бичгээр хослуулах | Хэрэгжүүлэх үйл ажиллагааны биелэлтийг хангасан хувь |   Байгууллагын өрөө тасалгааны хаяг, 5 албан хаагчийн нэрийн хуудсыг крилл, монгол бичгээр хослуулан хийсэн. Албан хэрэгцээний баримт бичгийн хаягийг хос бичгээр хослуулан бичиж хэвшсэн.<br>. Хэрэгжилт 100% |
| 1.4 | Хүний нөөц, сургалтын системийн бие даах хичээл цэсэнд “Хүмүүн бичиг” сонин, болон цахим хичээлүүдийг байршуулж, албан хаагчдыг Монгол бичиг бие дааж сурах орчин нөхцлийг бүрдүүлэх | Хүний нөөц, сургалтын системийн бие даах хичээл цэсэнд байршуулсан хичээлийн тоо |  Хүний нөөц, сургалтын систем дэх Монгол бичгийн үндэсний хөтөлбөр цэсэнд байршсан хичээлүүдийг нийт 40 албан хаагч үзэж судалсан байна. Монгол бичгийн булан байгуулж “Хүмүүн бичиг” сонин, тайлбар толь зэргийг  байрлуулан албан хаагчдыг Монгол бичиг бие дааж сурах орчин нөхцлийг бүрдүүлсэн.<br>Хэрэгжилт 100% |
| 1.5 | Газар, хэлтсүүд монгол бичгийн аян өрнүүлэх | УБЕГ болон нэгж салбаруудын зохион байгуулсан аянд оролцсон албан хаагчдын тоо | УБЕГ-аас зохион байгуулсан Монгол бичгийн уралдаанд Цээл сумын улсын бүртгэгч Г.Мөнхцэцэг “Улсын бүртгэлийн байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцоо, үнэлэмж” эсээ хос бичгээр бичин оролцсон.<br>Албан хаагчдын үндэсний бичгээр цахимд бичих чадварыг дээшлүүлэх, албан хэргийг хос бичгээр боловсруулах, хэвлэх чадварт сургах зорилгоор “Хос бичигтэн” аян зарлаж хос бичгээр бичих уралдаан, улирал бүр 1 өдрийн ажлын тайланг байти фонтоор бичиж илтгэх хуудас ирүүлэх,  долоо хоног бүрийн 1 өдрийн ажлын 2 цагийг Монгол бичгийг бие даан судлан суралцах зэрэг ажлуудыг зохион байгуулаад байна.<br>Хос бичигтэн цэвэр бичгийн уралдаанд Цээл сумын Улсын бүртгэгч Г.Мөнхцэцэг I-р байр, Батсүмэр сумын улсын бүртгэгч Б.Мөнгөнцэцэг II-р байранд шалгарсан.<br>Хэрэгжилт 100% |
| **Хоёр. Албан хэргийг крилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн** | | | |

| орчин бүрдүүлж, бэлтгэл хангах зорилтын хүрээнд | | | |
|---|---|---|---|
| 2.1 | Монгол бичгийн албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглаж буй суурин/зөөврийн компьютерт криллээс монгол бичигт хөрвүүлэх программын сургалт зохион байгуулах. | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | Архив, бичиг хэргийн эрхлэгч Б.Уянга монгол бичгийн цахим бичвэрийн сургалтад хамрагдсан. Мөн хэлтсийн 14 албан хаагчийн албан хэрэгцээний суурин компьютерт монгол бичгээр бичих байти фонтын тохиргоог хийн бие даан судалж байна. Хэрэгжилт 100% |

**ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:**

**УЛСЫН БҮРТГЭГЧ С.МӨНХЗУЛ**